

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/07/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас: 99177546 Аудитор: С.Санчирмаа Утас:99282488	Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn Цахим хаяг: Sanchirmaas@audit.gov.mn
---	---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25

№

98

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Говь-Алтай аймгийн Бугат сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Бугат сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.


ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН БУГАТ
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
А.МЯГМАРШАГДАР ТАНАА

07922142

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	187,618,169.00	212,161,100.27
33	АВЛАГА	40,902,479.00	32,379,728.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,044,391.00	443,640.00
33500	Бусад авлага	39,858,088.00	31,936,088.00
33510	Байгууллагаас авах авлага	39,858,088.00	31,936,088.00
35	БАРАА МАТЕРИАЛ	146,715,690.00	155,871,372.27
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	150,000.00
35400	Хангамжийн материал	38,075,690.00	72,831,372.27
35410	Бичиг хэргийн материал	69,000.00	285,000.00
35420	Аж ахуйн материал	13,020,250.00	11,680,250.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,000,000.00	1,200,000.00
35440	Түлш, шатах тослох материал	8,960,000.00	12,784,000.00
35450	Барилгын засварын материал	387,000.00	333,000.00
35470	Бусад хангамжийн материал	14,639,440.00	46,549,122.27
35600	Мал амьтад	108,640,000.00	82,890,000.00
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	-	23,910,000.00
36900	БЗЭБуй эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	-	23,910,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	940,938,149.60	866,947,581.13
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	940,938,149.60	866,947,581.13
39200	Биет хөрөнгө	858,797,024.60	785,068,956.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	553,828,860.64	574,398,860.64
39202	Хуримтлагдсан элэгдэл	(98,581,583.81)	(139,781,405.50)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	234,778,500.00	211,978,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(88,449,478.96)	(108,833,145.51)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	99,396,384.00	94,141,002.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(36,382,345.91)	(46,970,636.69)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,766,993.80	21,925,294.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,506,724.19)	(14,117,274.00)
39209	Зам, гүүрийн байгууламж	86,912,226.00	86,912,226.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(11,588,296.80)	(17,382,445.20)
39214	Бусад үндсэн хөрөнгө	174,803,923.00	209,408,824.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(66,268,383.17)	(87,697,794.25)
39217	Ном	1,086,950.00	1,086,950.00
39300	Биет бус хөрөнгө	82,141,125.00	81,878,625.00
39301	Програм хангамж	3,050,000.00	2,050,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,546,875.00)	(1,809,375.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	81,638,000.00	81,638,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,128,556,318.60	1,079,108,681.40
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,128,556,318.60	1,079,108,681.40
51	Засгийн газрын хувь оролцоо	1,128,556,318.60	1,079,108,681.40
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	599,593,645.02	599,593,645.02
51200	Хуримтлагдсан үр дүн	306,996,719.49	257,549,082.29
51210	Өмнөх үеийн үр дүн	173,394,599.37	306,996,719.49
51220	Тайлант үеийн үр дүн	133,602,120.12	(49,447,637.20)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	221,965,954.09	221,965,954.09
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,128,556,318.60	1,079,108,681.40

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	559,133,052.00	481,746,793.91
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	173,764,275.00	112,830,633.91

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

120	Нийтлэг татварын бус орлого	173,764,275.00	112,830,633.91
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	173,764,275.00	112,830,633.91
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	173,764,275.00	112,830,633.91
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	385,368,777.00	368,916,160.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	50,743,577.00	30,800,160.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	5,600,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,375,800.00	4,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	47,931,777.00	5,964,160.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,436,000.00	15,036,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	334,625,200.00	338,116,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	334,625,200.00	338,116,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	425,530,931.88	527,087,764.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	425,530,931.88	527,087,764.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	407,983,596.01	520,655,360.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	220,564,634.13	235,690,249.85
210101	Үндсэн цалин	126,466,551.28	146,465,924.92
210102	Нэмэгдэл	52,977,657.41	54,266,953.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	4,749,999.20
210104	Урамшуулал	15,333,225.44	8,300,972.60
210105	Гэрээт ажлын хөлс	25,787,200.00	21,906,399.63
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,252,066.00	31,711,687.00
210201	Тэтгэврийн даатгал	18,764,201.00	22,467,639.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,920,681.00	2,318,076.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,347,429.00	1,857,261.00
210204	Ажилгүйдлийн даатгал	474,524.00	460,314.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,745,231.00	4,608,397.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,378,113.00	19,800,381.00
210301	Гэрэл, цахилгаан	1,782,113.00	2,899,381.00
210302	Түлш, халаалт	15,526,000.00	16,876,000.00
210303	Цэвэр, бохир ус	70,000.00	25,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,014,960.00	53,254,300.00
210401	Бичиг хэрэг	1,772,620.00	1,703,670.00
210402	Тээвэр, шатахуун	17,000,000.00	18,913,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,747,340.00	1,686,730.00
210404	Ном, хэвлэл	30,000.00	15,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	420,000.00	3,128,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,505,000.00	27,807,900.00
210408	Бараа материал акталсны зардал	540,000.00	0.00
2105	Нормативт зардал	964,500.00	1,482,500.00
210502	Хоол, хүнс	964,500.00	982,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	447,500.00	1,854,000.00
210604	Урсгал засвар	447,500.00	1,854,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,215,000.00	1,694,000.00
210702	Дотоод албан томилолт	3,215,000.00	1,694,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,376,809.00	6,568,789.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,953,689.00	5,814,160.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	640,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	118,200.00	54,450.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	50,920.00	71,288.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	320,000.00	340,000.00
210807	Газрын төлбөр	250,000.00	233,891.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	104,770,013.88	168,599,453.67
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,609,800.00	45,702,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	25,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	98,760,213.88	122,872,053.67
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,547,335.87	6,432,404.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,790,000.00	2,285,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,790,000.00	2,285,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,757,335.87	4,147,404.15
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,321,335.87	2,849,404.15
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,436,000.00	1,298,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	133,602,120.12	-45,340,970.76
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	4,106,666.44
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	4,106,666.44
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	133,602,120.12	-49,447,637.20

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	599,593,645.02	221,965,954.09	173,394,599.37	994,954,198.48
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	599,593,645.02	221,965,954.09	173,394,599.37	994,954,198.48
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	133,602,120.12	133,602,120.12
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	599,593,645.02	221,965,954.09	306,996,719.49	1,128,556,318.60
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	599,593,645.02	221,965,954.09	306,996,719.49	1,128,556,318.60
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	599,593,645.02	221,965,954.09	306,996,719.49	1,128,556,318.60
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-49,447,637.20	-49,447,637.20
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	599,593,645.02	221,965,954.09	257,549,082.29	1,079,108,681.40

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	385,368,777.00	408,774,248.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	385,368,777.00	408,774,248.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	50,743,577.00	70,658,248.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	5,600,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,375,800.00	4,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	47,931,777.00	45,822,248.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,436,000.00	15,036,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	334,625,200.00	338,116,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	334,625,200.00	338,116,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	378,130,777.00	383,064,248.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	378,130,777.00	383,064,248.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	320,725,353.13	344,695,755.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	221,609,025.13	235,089,498.85
210101	Үндсэн цалин	126,466,551.28	144,658,920.00
210102	Нэмэгдэл	54,022,048.41	57,944,179.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	5,279,999.35
210104	Урамшуулал	15,333,225.44	5,000,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	25,787,200.00	22,206,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,252,066.00	31,711,687.00
210201	Тэтгэврийн даатгал	18,764,201.00	22,467,639.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,920,681.00	2,318,076.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,347,429.00	1,857,261.00
210204	Ажилгүйдлийн даатгал	474,524.00	460,314.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,745,231.00	4,608,397.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,490,113.00	23,624,381.00
210301	Гэрэл, цахилгаан	1,782,113.00	2,899,381.00
210302	Түлш, халаалт	23,638,000.00	20,700,000.00
210303	Цэвэр, бохир ус	70,000.00	25,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,431,040.00	21,268,400.00
210401	Бичиг хэрэг	1,998,700.00	1,794,670.00
210402	Тээвэр, шатахуун	17,000,000.00	16,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,747,340.00	1,686,730.00
210404	Ном, хэвлэл	75,000.00	115,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	680,000.00	572,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	930,000.00	600,000.00
2105	Нормативт зардал	1,454,500.00	1,550,000.00
210502	Хоол, хүнс	954,500.00	1,050,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,547,000.00	2,200,000.00

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	262,000.00	200,000.00
210604	Урсгал засвар	1,285,000.00	2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,215,000.00	1,694,000.00
210702	Дотоод албан томилолт	3,215,000.00	1,694,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,376,809.00	6,568,789.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,953,689.00	5,814,160.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	640,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	118,200.00	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	50,920.00	71,288.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	320,000.00	340,000.00
210807	Газрын төлбөр	250,000.00	233,891.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,349,800.00	20,989,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,949,800.00	20,789,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,405,423.87	38,368,492.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,790,000.00	2,285,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,790,000.00	2,285,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	54,615,423.87	36,083,492.15
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,321,335.87	2,849,404.15
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	41,294,088.00	33,234,088.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	7,238,000.00	25,710,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	7,238,000.00	25,710,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,238,000.00	25,710,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,238,000.00	25,710,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,238,000.00	25,710,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-7,238,000.00	-25,710,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төсвийн хэмнэлт+, хэмнэлт-	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	338,116,000.00	335,266,595.85	2,849,404.15	99%
УРСГАЛ ЗАРДАЛ	338,116,000.00	335,266,595.85	2,849,404.15	99%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	335,816,000.00	332,981,595.85	2,834,404.15	99%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	236,550,400.00	235,089,498.85	1,460,901.15	99%
Үндсэн цалин	145,758,000.00	144,658,920.00	1,099,080.00	99%
Нэмэгдэл	58,306,000.00	57,944,179.50	361,820.50	99%
Унаа хоолны хөнгөлөлт	5,280,000.00	5,279,999.35	0.65	100%
Урамшуулал	5,000,000.00	5,000,000.00	0.00	100%
Гэрээт ажлын хөлс	22,206,400.00	22,206,400.00	0.00	100%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,894,300.00	31,711,687.00	182,613.00	99%
Тэтгэврийн даатгал	22,592,300.00	22,467,639.00	124,661.00	99%
Тэтгэмжийн даатгал	2,325,500.00	2,318,076.00	7,424.00	100%

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

ҮОМШӨ-ний даатгал	1,860,400.00	1,857,261.00	3,139.00	100%
Ажилгүйдлийн даатгал	465,100.00	460,314.00	4,786.00	99%
Эрүүл мэндийн даатгал	4,651,000.00	4,608,397.00	42,603.00	99%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,650,000.00	23,624,381.00	25,619.00	100%
Гэрэл, цахилгаан	2,900,000.00	2,899,381.00	619.00	100%
Түлш, халаалт	20,700,000.00	20,700,000.00	0.00	100%
Цэвэр, бохир ус	50,000.00	25,000.00	25,000.00	50%
Хангамж, бараа материалын зардал	19,322,000.00	19,168,400.00	153,600.00	99%
Бичиг хэрэг	1,800,000.00	1,794,670.00	5,330.00	100%
Тээвэр, шатахуун	14,400,000.00	14,400,000.00	0.00	100%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,800,000.00	1,686,730.00	113,270.00	94%
Ном, хэвлэл	150,000.00	115,000.00	35,000.00	77%
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	572,000.00	572,000.00	0.00	100%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	600,000.00	0.00	100%
Нормативт зардал	1,550,000.00	1,550,000.00	0.00	100%
Хоол, хүнс	1,050,000.00	1,050,000.00	0.00	100%
Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00	0.00	100%
Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	3,000,000.00	0.00	100%
Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	1,000,000.00	0.00	100%
Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00	0.00	100%
Томилолт, зочны зардал	2,331,300.00	1,694,000.00	637,300.00	73%
Дотоод албан томилолт	2,331,300.00	1,694,000.00	637,300.00	73%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,118,000.00	754,629.00	363,371.00	67%
Даатгалын үйлчилгээ	200,000.00	54,450.00	145,550.00	27%
Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	71,288.00	78,712.00	48%
Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	55,000.00	33,000.00	63%
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	340,000.00	60,000.00	85%
Газрын төлбөр	280,000.00	233,891.00	46,109.00	84%
Бараа үйлчилгээний бусад зардал	16,400,000.00	16,389,000.00	11,000.00	100%
Бараа үйлчилгээний бусад зардал	16,200,000.00	16,189,000.00	11,000.00	100%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200,000.00	200,000.00	0.00	100%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,300,000.00	2,285,000.00	15,000.00	99%
Бусад урсгал шилжүүлэг	2,300,000.00	2,285,000.00	15,000.00	99%
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,300,000.00	2,285,000.00	15,000.00	99%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	338,116,000.00	338,116,000.00	0.00	100%
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	338,116,000.00	338,116,000.00	0.00	100%
Орон нутгийн төсвөөс	338,116,000.00	338,116,000.00	0.00	100%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
УРСГАЛ ЗАРДАЛ	-	46,748,248.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	13,514,160.00
Хангамж, бараа материалын зардал	-	2,100,000.00

Тээвэр, шатахуун		2,100,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	5,814,160.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		5,814,160.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,600,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал		5,600,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	33,234,088.00
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	33,234,088.00
Төвлөрүүлэх шилжүүлэг		33,234,088.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	23,910,000.00
Дотоод эх үүсвэрээр	-	23,910,000.00
Бусад хөрөнгө		23,910,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		70,658,248.0
Нэмэлт санхүүжилтийн орлого		70,658,248.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		5,600,000.00
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4,200,000.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		45,822,248.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		15,036,000.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Санчирмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 3/07 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Бугат сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

“Монгол Улсын үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн чиг үүргийг хэрэгжүүлж, нутгийн өөрөө удирдах ёсны чадавхыг дээшлүүлэх, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх “Монгол Улсын үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн чиг үүргийг хэрэгжүүлж, нутгийн өөрөө удирдах ёсны чадавхыг дээшлүүлэх, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх ойрын бодлогыг зөв зохистой тодорхойлох иргэдийн ашгийг хамгаалан, сайн сайхан амьдрах орчин бүрдүүлэх хүний хөгжлийг бүх талаар хангахад оршино”

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 385.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 7.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 6.2 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 506.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 10.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 8.1 сая төгрөгөөр тогтоогдож байна.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5 хувиар буюу 49.4 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгийн данс байна.

Авлага дансны үлдэгдэл 32.4 сая төгрөг болж өссөн нь гүйцэтгэлээр санхүүжиж нийгмийн даатгалын хэлтсээс авах, ажилчдаас авах авлагатай холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 155.9 сая төгрөг болж 9.1 сая төгрөгөөр өссөн нь хангамжийн материалтай холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 60.8 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 61.6 сая төгрөгийн хүлээн авч үйл ажиллагаандаа 113.2 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 155.9 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 890.5 сая төгрөг болж 50.1 сая төгрөгөөр буурсан нь 46.8 сая төгрөгийн барилга байгууламж, авто тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга, бусад үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө акталсантай холбоотой.

Өглөг дансны үлдэгдэлгүй.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,079.1 сая төгрөг болж 49.4 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 14 хувиар буюу 77.4 сая төгрөгөөр буурсан нь санхүүжилтийн орлого, төсөвт байгууллагын өөрийн орлоготой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 257.5 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 470.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 132.5 сая төгрөгөөр бууруулж, 338.1 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс бага байгаа нь бараа материал танагдсантай холбоотой.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 2 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 338.1 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 338.1 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 335.3 сая төгрөгийг зарцуулж, 2.8 сая төгрөгийн орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 335.3 сая төгрөг буюу 99 хувьтай байгаа нь ажил олгогчоос цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 1.5 сая төгрөгөөр, нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 0.2 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 0.1 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 0.4 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатнаас 45.8 сая төгрөгийг, засаг даргын нөөц хөрөнгөнөөс 5.6 сая төгрөгийг, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 15.0 сая төгрөгийг, хандиваар 4.2 сая төгрөгийн орлогыг тайлагнаж, урсгал үйл ажиллагаанд 46.7 сая төгрөгийг зарцуулж, 33.2 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн. Нэмэлт санхүүжилтийн орлогыг хангамж, бараа материал, бараа үйлчилгээний бусад зардал, хөрөнгө, бусдаар гүйцэтгүүлэх зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд 2021 оны 720.0 сая төгрөгийн 57 мэдээллийг ил тод байршуулахаас 21.1 сая төгрөгийн 10 мэдээллийг ил тод байршуулж, 698.9 сая төгрөгийн 47 мэдээллийг мэдээлээгүй байсныг залруулсан.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 15.3 сая төгрөгийн төлбөрийн акт, 21.5 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага хүргүүлснээс хэрэгжээгүй үлдэгдэл 1.0 сая төгрөгийн төлбөрийн акт, 0.6 сая төгрөгийн албан шаардлага байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- ✓ бараа материалын дансны үлдэгдлийг тулган баталгаажуулах
- ✓ төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх
- ✓ авлагын барагдуулалтыг үзэх нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 142.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 111.8 сая төгрөгийн алдааг залруулж, 30.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 заалт зөвлөмжийг өглөө.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд 21.1 сая төгрөгийг, мөнгөн гүйлгээний тайланд 31.9 сая төгрөгийн залруулга хийсэн. Мөн Санхүүгийн тайлан болон татварын тодорхойлолт 61.6 сая төгрөгийн илүү, 0.2 сая төгрөгийн дутуу зөрүүтэй байсныг аудитын явцад 58.7 сая төгрөгийг залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

4.3 Албан шаардлага

Санхүүгийн тайлан болон татварын тодорхойлолт 2.8 сая төгрөгийн илүү, 0.2 сая төгрөгийн дутуу зөрүүтэй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

И-баримтгүй 25.4 сая төгрөгийн гүйлгээ хийсэн нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж,

бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлалгүйгээр 2.0 сая төгрөгөөр спортын арга хэмжээ зохион байгуулсан нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.6-т "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын 1.1 дэх заалт " Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа. Үүнд:

1. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Шилэн дансны цахим системд 57 мэдээлэл мэдээлэхээс 47 мэдээлэл хоцроож мэдээлсэн.

1.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ. 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалтыг мөрдөн мэдээллээ бүрэн оруулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Бугат сумын Засаг даргын тамгын газрын	6	142.3	2	111.8	0	0	3	30.5	1	0